



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/32

Баянхутаг сум

**МАЛ АМЬТНЫ ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС
ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ АРГА
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3, 21.3.1, 21.3.2 дахь заалтууд, Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дугаар сарын 03 ны өдрийн А/180 тоот захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Сумын нутаг дэвсгэрт байгаа мал амьтныг угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах төлөвлөгөөт арга хэмжээг 2025 оны 04 дугаар сарын 01 – ны өдрөөс эхлэн чанартай хийж гүйцэтгэхийг “Сац манал” ХХК-ны малын эмч Н.Санжаадамба, “Унаган туур” БГБХН –ны захирал Ж.Гэрэлмаа, “Буман сувд гэрэл” ХХК-ны малын эмч Х.Сувд-Эрдэнэ, “Чандмань талын тан” ХХК –ны малын эмч Ч.Зоригтчулуун, “Ханхар Их Арт” ХХК-ны малын эмч О.Эрдэнэбилэг нарт үүрэг болгосугай.

Шимэгчтэх өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн графикт хугацаанд нь орон нутагт чанартай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж хамтран ажиллахыг Жаргалант багийн засаг дарга /Д.Буянбат/, Улаан- Өндөр багийн засаг дарга /Д.Алтанчимэг/, Цантын хоолой багийн засаг дарга /Б.Алтангэрэл/ нарт үүрэг болгосугай.

2025 онд шимэгчтэх өвчинтэй тэмцэх, эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал, амьтны тоог нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Мал угаалгын ажлын үйл явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах, угаалга, туулгалт, боловсруулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийж мэргэжлийн байгууллагын заавар журмыг баримтлаагүй малчин, мал бүхий иргэд, МЭҮНэгжүүдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж Тарилгын явцын мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагад танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч /Б.Тожилсүрэн/-д даалгасугай.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21.3.1, 21.3.2 дахь заалтыг зөрчиж, мал сүргээ угаалга, туулгалт, боловсруулалтанд хамруулаагүй малчин, мал бүхий өрхөд мал эмнэлгийн гэрчилгээ олгохгүй байхыг Мал эмнэлгийн

үйлчилгээний нэгжүүд, баталгаажуулахгүй байхыг Мал эмнэлгийн тасаг хариуцсугай.

Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллан дүнг 2025 оны 11 дүгээр сарын 01 – ний дотор танилцуулахыг Засаг даргын тамгын газрын дарга /Г.Болд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЙГАЛМАА

Сумын Засаг Даргын 2025 оны
 01. сарын 07. -ны өдрийн
 4/32 тоот захирамжийн
 01. дүгээр хавсралт

БАЯНХУТАГ СУМЫН ХЭМЖЭЭНД 2025 ОНД ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ АРГА
 ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

		Шимэгчтэхийн арга хэмжээ / мян.тол/													
Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Угаалга				Туулгалт				Боловсруулалт				Нийт	
		үхэр	хонь	ямаа	бүгд	үхэр	хонь	ямаа	нохой	бүгд	үхэр	хонь	ямаа		бүгд
1	Сац манал	0.8	30.0	15.0	45.8	0.5	20.0	10.0	0.1	30.6	0.8	15.0	10.0	25.8	102.2
2	Унаган туур	1.0	32.0	12.0	45.0	0.6	12.0	8.0	0.1	20.7	0.6	12.0	12.0	24.6	90.3
3	Чандмань талын тан	0.5	7.5	6.0	14.0	0.1	3.0	3.0		6.1	0.4	3.0	2.0	5.4	25.5
4	Бумансувд гэрэл	0.5	5.0	3.0	8.5	0.1	5.0	3.5		8.6	0.3	5.0	3.5	8.8	25.9
5	Ханхар Их Арт	0.5	5.0	4.0	9.5	0.3	5.0	1.5		6.8	1	5.0	3.5	9.5	25.8
	Бүгд	3.3	79.5	40.0	122.8	1.6	45.0	26.0	0.2	72.8	3.1	40.0	31.0	74.1	269.7